



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 04 өдөр


Дугаар А/92

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн ашиглалт засвар үйлчилгээнд хяналт тавьж ажиллах Төрийн бус байгууллагад олгох 50.130.00 /тавин сая нэг зуун гучин мянган/ төгрөгийг хотын гэрэлтүүлгийн ашиглалт засвар үйлчилгээний зардлын захиалагчийн хяналтын зардлаас, Хот тосгон ба суурин газрын гудамж талбайн гэрэлтүүлгийн стандартыг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын зардал болох 28.000.000 /хорин найман сая/ төгрөгийг хотын гэрэлтүүлгийн ашиглалт засвар үйлчилгээний зардлын хаврын их засвар болон өвөлжилтийн бэлтгэл ажлын зардлаас тус тус гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

